# “ОЧИР ТӨВ” ХХК-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## ТӨСЛҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**БАЙГУУЛЛАГЫН НЭР:** “ОЧИР ТӨВ” ХХК

**ТӨСЛҮҮДИЙН НЭР:**

- “ТАСГИЙН ОВОО” УУРХАЙН /БУТЛАН АНГИЛАХ ҮЙЛДВЭР/
  /ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН ДУГААР :MV-012161/
- БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР /УУРЫН ЗУУХТАЙ/

**ТӨСЛҮҮДИЙН БАЙРШИЛ:**

“ТАСГИЙН ОВОО” УУРХАЙН /БУТЛАН АНГИЛАХ ҮЙЛДВЭР/ БОЛОН БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР /УУРЫН ЗУУХТАЙ/ ТӨСЛҮҮД НЬ ОРХОН АЙМАГ, БАЯН - ӨНДӨР СУМ /ЭРДЭНЭТ ХОТ/ ГОВИЛ БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАДАГ.

**ҮЙЛДВЭРЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН:**

- БАРИЛГЫН ЧУЛУУ ОЛБОРЛОЖ, ДАЙРГА ҮЙЛДВЭРЛЭХ /0-5мм, 5-10мм,10-20мм/
- М100 – М550 ХҮРТЭЛ МАРКЫН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ

**ТӨСЛҮҮДИЙН ХҮЧИН ЧАДАЛ:**

- УУРХАЙ НЬ ЖИЛД 100,0 МЯН.$М^3$ БАРИЛГЫН ЧУЛУУ ОЛБОРЛОЖ БУТЛАН АНГИЛАХ ХҮЧИН ЧАДАЛТАЙ
- БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР /УУРЫН ЗУУХТАЙ/ ЦАГТ 90 $М^3$ БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ХҮЧИН ЧАДАЛТАЙ.

# БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР












**“ТАСГИЙН ОВОО” УУРХАЙН /БУТЛАН АНГИЛАХ ҮЙЛДВЭР/ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН ДУГААР : MV-012161**









# 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт-1

## 1.1 Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| д/д | Хийгдэх ажил | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Материал үйлдвэрлэлийн алба, дайрганы уурхайд ажиллаж буй том оврын машин механизмуудын оношлогоонд хамруулж, хөдөлгүүрээс гарах утаанд хяналт тавих | Материал үйлдвэрлэлийн бааз, Дайрганы уурхай | м2 | Агаар орчны шинжилгээний үр дүн | “Очир төв” ХХК-нь жил бүр Орхон аймгийн автотээврийн үндэсний төвтэй хамтран үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцож буй машин механизмуудыг үзлэг оношлогоонд хамруулж тос, тосолгоог цаг тухайд нь сольж ажилласан. Агаарын орчны бохирдуулагчийг Стандарт MNS4585:2016 шаардлагын дагуу хэвийн хэмжээнд барьж ажилласан. |
| 2. | Үйлдвэрлэлийн талбай , зам талбайг усаар шүршиж авто машины хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах | Материал үйлдвэрлэлийн бааз, Дайрганы уурхайн зам талбай | м2 | Агаар орчны шинжилгээний үр дүн | Барилгын материалын үйлдвэрүүд нь жилийн 4-10 сарын хугацаанд хэвийн горимоор ажилладаг тул хамгийн их хуурайшилттай тоосжилт ихтэй саруудад үйлдвэрийн орчны зам талбайг усаар шүршиж тоосжилтийг бууруулах арга хэмжээг авч ажилласан. Энэ онд “Гал Сэнтий” ХХК-ийн үйлдвэрлэж буй саарал уснаас 140 тн усыг үйлдвэрлэлийн зам талбайг шүршиж ажилд худалдан авч хэрэглэсэн. MNS 4943:2015 техникийн саарал усыг тоосжилтыг бууруулах арга хэмжээний ажлын хүрээнд хэрэглэснээр үйлдвэрийн доторх шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулж, орчны хөрсний бохирдлоос сэргийлсэн. |

| д/д | Хийгдэх ажил | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 3. | Уурын зуухнаас ялгарах утаанд хяналт тавих | Материал үйлдвэрлэлийн бааз, Уурын зуух | | Агаар орчны шинжилгээний үр дүн | 2020 онд CDZL067-85/60-AL1 маркийн уурын зуухыг ашиглалтанд оруулснаар агаарыг бохирдуулагч хорт хийн хэмжээг багасгасан, байгаль орчинд ээлтэй. Мөн шаталт сайтай, утаа бага ялгаруулах түлшийг авч хэрэглэх тал дээр хяналттай ажиллаж байна. |
| 4. | Бетон зуурмагийн үйлдвэр болон дайрганы уурхайд ажиллаж буй том оврын машин механизмын засварын гаражид утаа сорогч тавих | Материал үйлдвэрлэлийн бааз, Дайрганы уурхай | м2 | Агаар орчны шинжилгээний үр дүн | Машин механизмуудын засварын гаражид утаа сорогчийг байрлуулснаар хөдөлгүүрээс гарах орчныг бохирдуулах хорт хийн хэмжээг бууруулж багассан. /Зургийг хавсаргав./ |

Үйлдвэрийн баазын машин механизмын засварын гараж







Материал үйлдвэрлэлийн баазын зам талбайг усаар шүршиж тоосжилт бууруулах











1.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд учруулж болох болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт-2

| д/д | Хийгдэх ажил | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Материал үйлдвэрлэлийн баазын гүний худгийн усыг шинжилгээнд хамруулах | Материал үйлдвэрлэлийн бааз | мг/л | Орхон аймгийн МХГ-ын лабораторийн үр дүн | “Очир төв” ХХК-ийн БОМТөлөвлөгөөнд тусгасан хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу жилд 2 удаагийн давтамжтайгаар үйлдвэрлэлийн баазын нутаг дэвсгэр дэх гүний худгийн усны дээжийг шинжлүүлсэн. Гүний усны дээжид 15 үзүүлэлтээр шинжилгээ гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнг газрын доорх усыг бохирдуулагч бодисын MNS 6148:2010 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулахад стандарт шаардлагыг хангасан. |
| 2. | Дайрганы уурхайн үйлдвэрлэлийн бүсийн үерийн уснаас хамгаалах суваг шуудууг тогтмол цэвэрлэх | Дайрганы уурхай | Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ, м3 | Хог хаягдлын хэмжээг тайланд тусгах | Дайрганы уурхайд 936 ì орчим үерийн уснаас хамгаалах сувагтай, уг шуудууг тус хэсгийн ажилчид 14 хоног тутам цэвэрлэж нийт 17 м3 хог хаягдлыг ачиж хогийн цэгт тээвэрлэн хаясан. |

1.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт-3

| д/д | Хийгдэх ажил | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Дайрганы уурхайн орчинд хөрсний шинжилгээ хийлгэх | Дайрганы уурхай, | мг/кг | Хөрсний шинжилгээний үр дүн | Дайрганы уурхайн ажилчдын байр, хогийн цэг, бутлуурын дэргэд хөрсний 3 дээжид хөрсний эрүүл ахуй, хүнд металл, хими, механик шинж чанарын үзүүлэлтээр Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораториар шинжилгээ гүйцэтгүүлсэн. MNS 6341:2012, MNS 5367:2004, MNS 5850:2019, MNS 3310:1991, MNS 6824:2020 зэрэг стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй /Шинжилгээний үр дүнг хавсаргав./ |
| 2. | Үйлдвэрлэлийн баазын бетон зуурмагийн үйлдвэр, шатахуун түгээх станц, уурын зуухны орчноос хөрсний шинжилгээ хийлгэх | Бетон зуурмагийн үйлдвэр, Уурын зуух, Шатахуун түгээх станц | мг/кг | Хөрсний шинжилгээний үр дүн | Бетон зуурмагийн үйлдвэр, Уурын зуух, Шатахуун түгээх станцын хөрсний 3 дээжид хөрсний эрүүл ахуй, хүнд металл, хими, механик шинж чанарын үзүүлэлтээр Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораториар шинжилгээ гүйцэтгүүлсэн. MNS 6341:2012, MNS 5367:2004, MNS 5850:2019, MNS 3310:1991, MNS 6824:2020 зэрэг стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй /Шинжилгээний үр дүнг хавсаргав./ |
| 3. | Үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг ангилан ялгаж , тээвэрлэн төвлөрсөн цэгт хаях | Дайрганы уурхай, Үйлдвэрлэлийн бааз, офис | Цэвэрлэсэн талбай-м2, хог хаягдлын хэмжээ, м3 | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Хот тохижуулах газартай гэрээ байгуулж Үйлдвэрийн бааз, дайрганы уурхай , конторын барилгаас гарах хог хаягдлыг ангилан өөрсдийн тээврээр төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн. Хог хаягдлын хэмжээ 80 м3 |
| 4. | Хөрсөн бүрхэвч замын нөлөөгөөр доройтох тул олон салаа зам үүсэхээс сэргийлж дайрганы уурхайгаас засмал зам хүртэл, вокзалын уулвараас үйлдвэрийн бааз хүртэлх авто замыг хусаж, тэгшилж сайжруулах | 3-н замын уулзвараас дайрганы уурхай хүртэл, вокзалын уулвараас үйлдвэрийн бааз хүртэлх авто зам | 2,2км | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Авто машины хөдөлгөөний нөлөөгөөр олон салаа зам гарч хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж 3-н замын уулзвараас дайрганы уурхай хүртэл, вокзалын уулвараас үйлдвэрийн бааз хүртэлх авто замыг автогрейдерээр хусаж, дүүргэлт хийж тэгшилж сайжруулсан. |

| д/д | Хийгдэх ажил | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 5. | Материал үйлдвэрлэлийн баазын хашаан дахь ажилчдын нүхэн жорлонг ариутгал халдваргүйжүүлэлт хийж дарах | Материал үйлдвэрлэлийн бааз, Бетон зуурмагийн үйлдвэр | ширхэг | Ариутгал халдваргүйжүүлэлт хийх | Материал үйлдвэрлэлийн бааз, Бетон зуурмагийн үйлдвэрийн ажилчдын нүхэн жорлонг "Цэцэн шунхлай" ХХК-иар ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж дарсан. |
| 6. | Дайрганы уурхайн ажилчдын эко 00 шинээр хийх | Дайрганы уурхай | ширхэг | Эко 00 | Дайрганы уурхайд ажилчдын эко 00 барьсан нүхэн жорлонгоос үүсэх хөрсний бохирдлын сөрөг нөлөөллийг бууруулсан. |

Ажилчдын душ, боловсон 00 барьж ашиглалтанд оруулсан нь ажилчдын ахуйн ариун цэвэр сайжирхаас
гадна хөрсний бохирдол үүсэхээс сэргийлсэн .







Цэцэн шунхлай ХХК-иар ариутгалыг ажлыг гүйцэтгүүлэх үеийн зураг







1.4 Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт-4

| д/д | Хийгдэх ажил | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Материал үйлдвэрлэлийн бааз, офисын хашаан дотор олон наст ургамлын үр тарьж ургамалжуулж тохижуулах | Үйлдвэрийн бааз, офисын хашаа | га | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | “Очир төв” ХХК-ийн хэсэг нэгжүүд хариуцсан талбайн орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ,олон наст ургамлын үр тарьж ургамалжуулах ажлыг жил бүр зохион байгуулдаг. |
| 2. | Дайрганы уурхайн үйлдвэрлэлийн бүсэд олон салаа зам гарахаас сэргийлэх | Дайрганы уурхай | га | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Дайрганы уурхайд ажиллаж байгаа машин техникүүдийн нөлөөгөөр олон салаа зам гарч ургамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж, тоосжилтыг усалгаагаар дарж, эвдрэлд орсон зам талбайг тухай бүр хусаж тэгшилж ажилладаг. |
| 3. | Баян-Өндөр сум Говил баг Хангал голын эрэгт тарьсан мод бордож услаж ургуулах | Ногоон төгөл байгуулах ажлын хүрээнд | ш | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Хангал голын эрэгт 2022 онд 500 ширхэг, 2023 онд 500 ширхэг улиас бургас, чацаргана, 2024 онд 500 ширхэг улаан бургас, хайлаас,2025 онд 500 ширхэг улаан бургас, шар бургас гэх мэт мод тарьсан бөгөөд хуурайшилт ихтэй саруудад усалгаа арчилгааг хийж гүйцэтгэсэн. |






“Очир төв” ХХК-ийн Офисын хашаа









### 1.5 Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт-5

| д/д | Хийгдэх ажил | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Дайрганы уурхайн үйлдвэрлэлийн бүсэд мал амьтан унаж, гэмтэхээс сэргийлэх | Дайрганы уурхай | 25 га | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Дайрганы уурхайн үйлдвэрлэлийн бүсэд мал амьтан орж, олборлолтын талбайд унаж гэмтэхээс сэргийлж жил бүр 7-10 сарын хугацаанд суваг шуудуу татаж, хамгаалалтын хаалга хийцийг шинэчлэн ажилладаг. /Уурхайн харуул ажлын талбайд байнгын оршин сууж эргүүл хийдэг./ |
| 2. | Амьтны аймагт | Дайрганы уурхай | | - | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын болон хотын орчны бүсэд хамрагдаж, нөлөөлөлд нь өртөгдөж ирсэн учраас амьтны аймгийн төрөл зүйлийн хувьд маш бага, ойр орчимдоо ой мод байхгүй задгай тул шавьж болон мэрэгчид ч мөн адил цөөн тоотой байдаг. |

## 2. НӨХӨН СЭРГЭЭЛТ

Хүснэгт-6

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Дайрганы уурхайд техникийн нөхөн сэргээлт хийх | Дайрганы уурхай | га | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | 2022 онд MV-012161 тоот тусгай зөвшөөрлийн нийт 25 га талбайд хайгуулын ажил хийгдэж нөөц нэмэгдүүлсэн тул 2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөөгүй бөгөөд цаашид уулын ажлын тайланд тодорхой хэмжээгээр төлөвлөж тусгаад гүйцэтгэнэ. Одоогоор тус орд газарт 8,98 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2,33 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн. |
| 2. | Дайрганы уурхайд биологийн нөхөн сэргээлт хийх | Дайрганы уурхай | га | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | 2022 онд MV-012161 тоот тусгай зөвшөөрлийн нийт 25 га талбайд хайгуулын ажил хийгдэж нөөц нэмэгдүүлсэн тул 2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөөгүй бөгөөд цаашид уулын ажлын тайланд тодорхой хэмжээгээр төлөвлөж тусгаад гүйцэтгэнэ. Одоогоор тус орд газарт 2,33 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн. |

## 3.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт-7

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймгийн нутаг дэвсгэрт мод тарих (Хангал голын эрэг) | Орхон аймаг Баян-Өндөр сум, Говил багийн нутаг Хангал голын эрэг | 0,2 га | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Орхон аймгийн БОГ-аас тухайлсан Баян-өндөр сумын Говил багийн нутаг дэвсгэрт орших Хангал голын эрэгт 500 ширхэг мод тарих ажлыг гүйцэтгэв. Уг ажлыг 2025 оны 05-р сарын 19-наас эхлэн 05-р сарын 24-ныг дуустал 6 хоногийн хугацаанд тарих нүхний хэмжээ, хар шороо, өтөг бууцыг стандартын дагуу бэлтгэж 500 ширхэг улаан, шар бургас модыг тарьж услаад БОАЖГ-ын мэргэжилтэнд шалгуулсан. 2025 оны 6-10 сар хүртэл усалгаа ургалтыг цаг тухайд нь хийж байсан бөгөөд нийт 500 ширхэг модноос 450 мод хэвийн ургаж, 50 ширхэг мод ургаагүй тул 2025 оны 10-р сарын 10-нд шинээр суулгац тарьж усалгааг хийж гүйцэтгэсэн. |
| 2. | Дүйцүүлэн хамгаалах ажил | Орхон аймаг, Баян-Өндөр сум | 1га | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Орхон аймгийн БОГ-аас заасан байршил буюу Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын зүүн урд энгэрт 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэв.Тус ажилд нийт 1275м3 хар шороог тээвэрлэн авчирч тарааж тэгшлээд, согоовор-33 кг, ерхөг-17 кг, цархас-17 кг зэрэг олон наст ургамлын үр цацаж гүйцэтгэсэн. |
| 3. | Хангал голын эрэгт тарьсан мод хамгаалах төмөр бетон шонтой өргөст торон хашаа барих | Орхон аймаг Баян-Өндөр сум, Говил багийн нутаг Хангал голын эрэг | 440м | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Төмөр бетон шон газарт бетон зуурмагаар бэхлэж, 200х15 м хэмжээтэй нийт 440м 4 үе өргөст төмөр татаж хамгаалалтын хашаа угсарсан. |
| 4. | Орхон аймаг Баян-Өндөр сум говил багт орших “Долоон булаг” сэргээн тохижуулах, хамгаалах | Орхон аймаг Баян-Өндөр сум, Говил багийн нутаг Хангал голын эрэг | | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | 2014 онд тохижуулсан төмөр бетон чулуун суурь, бетон шонг сэргээн будах мал амьтны нөлөөгөөр эвдэрсэн өргөст торыг шинээр татаж засвар арчилгаа хийсэн. /Зургийг хавсаргав/ |

Биологийн нөхөн сэргээлт хийхийн өмнөх зураг





**Сархиа уулын зүүн тал биологийн нөхөн сэргээлтийн ажил**






**Сархиа уулын зүүн тал биологийн нөхөн сэргээлтийн ажил**











**Мод тарих үеийн ажлын зураг /2025.05.24/**











**Намрын нөхөн тарилт усалгааны ажлын зураг /2025.10.10 /**









**“Долоон булаг ” Мал амьтны нөлөөгөөр эвдэрсэн хашааг сэргээн засварлах ажлын явц**





## 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт-8

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Дайрганы уурхайн орчимд малтай айл өрх буухыг таслан зогсоох, БОГ-ын мэргэжилтэнд мэдээлэх , хамтран ажиллах | Дайрганы уурхайн хүрээнд | - | - | Уурхайн нөлөөллийн бүсэд айл өрхийн өвөлжөө, зуслан, гар худаг байхгүй бөгөөд уурхай дээр байнгын харуул ажилладаг. |

## 5.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт-9

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Эртний олдвор илэрсэн тохиолдолд авран хамгаалах | Дайрганы уурхай, үйлдвэрлэлийн баазын хүрээнд | Тодорхойлох боломжгүй | - | Дайрганы уурхай, үйлдвэрлэлийн баазын эзэмшлийн талбайгаас 2025 онд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй болно. |

## 6.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Хүснэгт-10

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг ажлын байранд байнга бэлэн байлгах, хангалт хийж байх | Дайрганы уурхай, үйлдвэрлэлийн бааз, офис, барилга угсралтын ажлын нэгж хэсгүүд | - | Галын хор, Эмийн сан, Гал унраах багаж, мэдээллийн булан, анхааруулга тэмдэг тэмдэглэгээ | Гал түймэртэй тэмцэх багаж, тоног төхөөрөмж (галын хор, сүх, бээлий, элс гэх мэт). Гал унтраагуурын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, бүх нэгж хэсгүүдэд галын хорыг шинэчлэн цэнэглэж байрлуулсан. Ил гал гаргахаас урьдчилан сэргийлэх санамж анхааруулах тэмдэг тэмдэглэгээг бүх нэгж хэсгүүдийн ажлын байранд байрлуулсан. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эмийн сан бүх нэгж хэсгүүдийн ажлын байранд байнгын бэлэн байдаг. Галын хор 70 ширхэг, эмийн сан 10 ширхэг / Зургийг хавсаргав./ |
| 2. | Үерийн ус орж ирэхээс сэргийлж суваг,шуудууг цэвэрлэх | Дайрганы уурхай | м | 936м | Үерийн ус сувгаас халихаас сэргийлж тогтмол үзлэг хийж 14 хоногт 1 удаа цэвэрлэж байсан. |
| 3. | Дайрганы уурхайн олборлолтонд өртсөн хананд үзлэг хийх | Дайрганы уурхай | - | Хананд үзлэг хийх | Ажлын явцад Уурхайн хананд 7 хоногт 1 удаа үзлэг хийсэн. Хагарал үүссэн, нурах эрсдэлтэй хана байгаагүй. Аюултай бүсийн хязгаар тогтоон орохыг хориглосон тэмдэг тэмдэглэгээг тавьсан. |
| 4. | Дайрганы уурхайн талбай дээр дизель түлш асгарахаас сэргийлэх | Дайрганы уурхай | | | Уурхайн талбай дээр машин техникийг зөөврөөр цэнэглэх үед түлш асгарахаас сэргийлж элс шороо бүхий тусгайлсан талбайд цэнэглэлт хийх, мөн засвар үйлчилгээг хийдэг. |
| 5. | Үйлдвэрлэлийн баазын ШТС-ын ачаа буух, түгээх талбайд хатуу хучилт хийх | Үйлдвэрийн бааз ШТС | | | Үйлдвэрлэлийн баазын ШТС-ын ачаа буулгах, шатахуун түгээх талбайг түлш асгарч гарч болзошгүй галын аюул ослоос мөн хөрсний бохирдлоос сэргийлж бетон талбай цутгасан. /Зургийг хавсаргав./ |
| 6. | Материал үйлдвэрлэлийн баазын уурын зуухны нүүрс болон үнс хадгалах талбайг тохижуулах | Материал үйдвэрлэлийн бааз, Уурын зуух | | Бетон талбай хашилт, үнс хөргөх тусгай төмөр сав | Материал үйлдвэрлэлийн бааз нь жил бүрийн 10-р сарын 1-нээс 12-р сарын 01 хүртэл өөрийн дотоодын уурын зуухын ажиллуулдаг. Ажиллах явцад хэрэглэх нүүрс хадгалах талбайг бетон блокоор хашиж тохижуулсан. Мөн хаягдлаас гарах үнсийг хөргөж аюулгүй болсны дараа барилгын дулаалгын материалд хэрэглэж байна. |

**Бетон зуурмагийн үйлдвэр галын булан**



**Машин механизмын гараж**



**Уурын зуухны галын булан**



**Офисын барилгын галын булан**



**ШТС-ын галын булан**






**Материалын агуулахын галын булан**



**Эмийн сан, анхан шатны тусламжийн хэрэгсэл**




**Үйлдвэрлэлийн баазын мэдээллийн булан**



**Уурын зуухны**







# 7.ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хүснэгт-11

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хэсэг нэгжүүдийн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зориулалтын саванд ангилан ялгаж, хуваарийн дагуу их цэвэрлэгээ зохион байгуулж ачуулах | Дайрганы уурхай, үйлдвэрлэлийн бааз, офис | 80м3 | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлагын дагуу бүх нэгж хэсгүүд дээр энгийн ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж хаядаг хогийн савтай Хот тохижуулах газартай гэрээ байгуулсан бөгөөд өөрсдийн тээврээр хогийн цэгт хүргэж хаясан. /Зургийн хавсаргав./ |
| 2. | Машин механизмын тосолгооноос гарсан ашигласан тосыг аюултай хог хаягдлын төрөлд бүртгэл үүсгэх | ШТС, дайрганы уурхай, үйлдвэрлэлийн бааз | л | 100 | Дайрганы уурхай, бетон зуурмагийн үйлдвэрлэлд ажиллаж буй машин механизмын ажилласан тос, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ашигласан тос,тосолгооны арчих материалыг аюултай хог хаягдлын үүсгэгчийн бүртгэлээр ангилан ялгаж өөрийн төмөр бетон хийц эдлэлийн хэсэгт бетоны ажлын хэв хашмалын тосолгоонд хэрэглэсэн. |
| 3. | Орхон аймгийн БОГ-аас зарласан хаврын хог цэвэрлэгээний аян | Даваат өргөө багийн хогийн цэг | | Нийгмийн хариуцлагын хүрээнд | 2025 оны 5-р сарын 26 ны өдөр БОГ-аас зааж өгсөн цэгт буюу Орхон аймгийн Баян-Өндөр сум Их залуу баг Даваат өргөө багийн хогийн цэгийг дарж булах, ачих ажлыг авто ачигчаар гүйцэтгэсэн / 14 цаг/ |

**Материал үйлдвэрлэлийн баазын хог цэвэрлэгээний ажил**










**ШТС-ын хогийн сав**







**ШТС-ын гаднах хатуу хучилт**



**Бетон зуурмагийн үйлдвэр, конторын хогийн сав**



## 8.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт-12

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Орчны агаарын чанарын шинжилгээ хийлгэх | Дайрганы уурхай, Бетон зуурмагийн үйлдвэр, Уурын зуух, ШТС | мг/м3 | Агаарын шинжилгээний үр дүн | Дайрганы уурхайгаас 4 дээж, материал үйлдвэрлэлийн баазын хэсгээс 3 дээж, нийт 7 дээжид хэмжилтийг гүйцэтгэсэн.Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг баримтлан ажилладаг. |
| 2. | Хөрсний химийн шинжилгээ хийлгэх | Дайрганы уурхай, Бетон зуурмагийн үйлдвэр, Уурын зуух, ШТС | мг/кг | Хөрсний шинжилгээний үр дүн | Дайрганы уурхай, Бетон зуурмагийн үйлдвэр, Уурын зуух, Шатахуун түгээх станцын байршилд хөрсний дээжид хөрсний эрүүл ахуй, хүнд металл, хими, механик шинж чанарын үзүүлэлтээр Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораториар шинжилгээ гүйцэтгүүлсэн. MNS 6341:2012, MNS 5367:2004, MNS 5850:2019, MNS 3310:1991, MNS 6824:2020 зэрэг стандартуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ хэтрээгүй тул хөрс бохирдуулагчийг харьцуулж доройтуулахгүй хамгаалж ажилладаг. |
| 3. | Агаар дахь тоосны агууламжийн шинжилгээ хийлгэх | Дайрганы уурхай, Үйлдвэрлэлийн бааз | мг/м3 | Тоос, тоосонцорыг хэмжих PM10, PM2.5 багаж | Дайрганы уурхай, үйлдвэрлэлийн баазын хэсгээс нийт 6 дээж авч хяналт шинжилгээг хийлгэсэн. Үйлдвэрийн бүсийн гадаад орчны агаарын чанарын үзүүлэлтийг Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг баримтлан ажилласан. |
| 4. | Үйлдвэрлэлийн баазын гүний худгийн усыг шинжилгээнд хамруулах | Үйлдвэрлэлийн бааз | мг/л | Орхон аймгийн МХГ-ын лабораторийн үр дүн | “Очир төв” ХХК-ийн БОМТөлөвлөгөөнд тусгасан хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу жилд 2 удаагийн давтамжтайгаар үйлдвэрлэлийн баазын нутаг дэвсгэр дэх гүний худгийн усны дээжийг шинжлүүлсэн. Гүний усны дээжид 15 үзүүлэлтээр шинжилгээ гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнг газрын доорх усыг бохирдуулагч бодисын MNS 6148:2010 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулахад стандарт шаардлагыг хангаж байсан. |

# 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүснэгт-13

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Байгаль орчны аудит хийлгэх | Материал үйлдвэрлэлийн бааз, Дайрганы уурхай | - | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Байгаль орчны аудитыг мэргэжлийн эрх бүхий “Эковишн” ХХК-иар хийлгэсэн. 2025 онд |
| 2. | Ногоон төгөл төслийг хүрээнд тарьсан мод услах, арчлах багаж хэрэгсэл худалдан авах | Хангал голын эрэг дагуух талбай | - | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Хангал голын эрэгт тарьсан моднуудын усалгаа арчилгааг хийхэд зориулж ус шахах насос шинээр худалдан авсан. Мөн гар багаж хэрэгслүүд худалдан авсан. |
| 3. | Нийт ажилчдад байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг танилцуулах , гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх сургалт, хурал зохион байгуулах | Дайрганы уурхай, үйлдвэрлэлийн бааз, офис, барилга угсралтын ажлын нэгж хэсгүүд | - | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Нийт хэсэг нэгжүүдийн ажилчдад байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж танилцуулах, байгаль орчинд ээлтэй ажиллаж амьдрах гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай сургалтанд хамруулсан. |
| 4. | Байгаль орчныг хамгаалах чиглэлээр орон нутгаас барьж байгаа бодлого арга хэмжээнүүдийг дэмжиж ажиллах | Аймаг орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд “Очир төв” ХХК хамтран ажиллах | - | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Орхон аймгийн БОАЖГ-ын саналаар Дүйцүүлэн хамгаалах ажлыг Сархиа уулын зүүн талд 1 га талбайд биологийн нөхөн сэргээлт, Говил багийн нутаг дэвсгэрт Хангал голын эрэгт 500ширхэг мод тарьж хамгаалалтын торон хашааг барьж хүлээлгэн өгсөн. Мөн жил бүр “ Долоон булаг” рашааны эхийг тохижуулах хамгаалан арчилах саналын дагуу хийж гүйцэтгэсэн. |
| 5. | Нийгмийн хариуцлагын хүрээнд ажил хийх | Баян-Өндөр сумын Говил баг | | Баян-Өндөр сумын Говил багийн засаг даргын хүсэлтээр | Орхон аймгийн Баян-Өндөр сум, Говил багийн засаг даргын хүсэлтээр дайрганы уурхайгаас 90м3 хайргыг тус багийн зам талбайн тохижилтын ажилд дэмжлэг болгон өгсөн. |









**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ**

| | |
|---|---|
| Зорилго *Purpose* | Байгаль орчны анхан шатны мэдлэг олгох : Хогон сургалт, Хог ангилан ялгах, Бодлого, журам. |
| Өдөр, Цаг *Date & Time* | 2025. 11. 12 10:00 — 12:00 |
| Хэлэлцүүлэг болсон газар *Location* | "ОТК"-ХХК-н ИЧБ-ын ХАБЭА сургалтын танхим |
| СУРГАЛТЫГ хөтлөгч *Facilitator* | Харанхүмэн (Эрдэнэт үйлдвэр 60-ын инженер, сургагч багш |

| № | Оролцогчийн нэр Participant | Албан тушаал Position | Гарын үсэг Signature |
|---|---|---|---|
| 1 | С. Өлзийсайхан | ЭСК. оператор | [illegible] |
| 2 | Ц. Санжжав | мастер | [illegible] |
| 3 | Х. Цэцэгмаа | нярав | Цэцэгмаа |
| 4 | Х. Гэрэлдэлгэр | оператор | [illegible] |
| 5 | Д. Баясгалан | жолооч | [illegible] |
| 6 | М. [illegible] | технологич | [illegible] |
| 7 | Г. [illegible] | оператор | [illegible] |
| 8 | Х. Нямсамбуу | жолооч | [illegible] |
| 9 | Б. [illegible] | оператор | [illegible] |
| 10 | Ц. [illegible] | оператор | [illegible] |
| 11 | Ж. Болдбилэг | жолооч | [illegible] |
| 12 | Р. Байгальмаа | үйлчлэгч | [illegible] |
| 13 | М. Мөнх-Эрдэнэ | оператор | [illegible] |
| 14 | Ш. Балдандорж | жолооч | [illegible] |
| 15 | Л. Тулгабаатар. | механик инженер | [illegible] |
| 16 | А. Эрдэнэбилэг | САНТЕХНИК | Эрдэнэбилэг |
| 17 | ОТГОНБААТАР .А | ГАГЦ | [illegible] |
| 18 | Амраа | ГАГЦ | Амраа |
| 19 | В. [illegible] | Засварчин | [illegible] |
| 20 | Д. Отгонням | Засварчин | [illegible] |
| 21 | П. Наранцогт | жолооч | Гарын үсэг |
| 22 | М. Баянцагаан | тогооч | [illegible] |
| 23 | Н. Энхтунгалаг | технологич | [illegible] |
| 24 | Э. Саран | ХАБЭА ажилтан | [illegible] |
| 25 | | | |

Page 1 of 2

## 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

Хүснэгт-14

| д/д | Хийгдэх ажил | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэмжих нэгж | Биелэлтийн шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэх ажлын хэсгийн гишүүдэд төлөвлөгөөний гүйцэтгэлийг танилцуулах | БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх бүрэн тайлан | - | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/168 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” ын ажлын хэсгийн гишүүдэд “Очир төв” ХХК-ийн 2025 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах |
| 2. | Говил багийн нутаг дэвсгэрт амьдарч буй иргэдэд БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах | БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх бүрэн тайлан | - | БОМТөлөвлөгөөнд тусгагдсанаар | Говил багийн иргэдийн нийтийн хуралдаанаар БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулж ИНХ-ын хуралдааны тогтоолоор иргэдийн амьдрах нөхцөлд сөрөг нөлөөлөл байхгүй, орчны эрүүл ахуйн шаардлагыг хангаж, лицензээр эзэмшдэг талбайдаа үйл ажиллагаа явуулах шаардлагыг авч ажилласан. |

## Байгаль орчныг хамгаалах төлөвлөөгөөний биелэлтийн зардлын тайлан

| д/д | Төлөвлөсөн арга хэмжээ | 2025 оны төлөвлөгөөний дүн /төгрөг/ | 2025 оны гүйцэтгэлийн дүн /төгрөг/ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд орчны хяналт шинжилгээг хийлгүүлэх | 1,780,000 | 807,000 | Хөрс, агаар судлалын лаборатори хамтран гүйцэтгэсэн. |
| 2. | Тээврийн хэрэгслүүдийг оношлогоонд хамруулах | 627,000 | 570,000 | Авто тээврийн үндэсний төв “Очир төв” ХХК |
| 3. | Салаа зам гарах , хөрсний элэгдэл үүсэхээс сэргийлж уурхай болон үйлдвэрлэлийн баазаас төв зам хүртэлх газрыг хусаж тэгшилэх, зам талбай усалгаа хийх | 3,000,000 | 3,200,000 | “Очир төв” ХХК гүйцэтгэсэн |
| 4. | Нүхэн жорлон дарах, үйлдвэрийн бааз, дайрганы уурхай, офисын ажилчдын өрөөнд ариутгал халдваргүйжилт хийлгэх | 1,260,000 | 540,000 | “Цэцэн шунхлай “ ХХК |
| 5. | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах ажил гүйцэтгэх | 23,800,000 | 26,348,000 | БОГ-тай хамтран “Очир төв” ХХК гүйцэтгэсэн. |
| 6. | Ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээнээс гарсан хог хаягдлыг ангилж ялган тээвэрлэж хогийн цэгт хаях, ариутгал хийлгэх | 4,554,000 | 5,435,000 | “Очир төв” ХХК гүйцэтгэсэн |
| 7. | Дайрганы уурхай, Үйлдвэрлэлийн баазын доторх зам талбайд усалгаа хийх, тоосжилтийг бууруулах | 1,150,000 | 509,100 | “Гал сэнтий” ХХК<br>“Очир төв” ХХК гүйцэтгэсэн |
| | | 36,171,000 | 37,409,100 | |

“Тасгийн овоо” дайрганы уурхайн 2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд 100,0 мян,м3 уулын цул олборлохоор тусгасны бөгөөд 2025 оны 11-р сарын 01 ний байдлаар 31458 м3 уулын цул олборлож бутлан ангилаад өөрийн дотоодын Бетон зуурмагийн үйлдвэр, хувь хүн, компаниудад нийлүүлсэн байна.

Бетон зуурмагийн үйлдвэр нь 2025 оны 11-р сарын 01 байдлаар 5482,7 м3 бетон зуурмаг үйлдвэрлэж дотоодын барилга угсралтын ажилд болон гадны байгууллагуудад нийлүүлсэн байна.

2025 онд гарсан зардлууд:

- Өрөмдлөг, тэсэлгээний ажлын зардал-101,3 сая.төг
- Газрын төлбөрт-50,9 сая.төг
- АМНАТөлбөрт-28,8сая.төг
- Тусгай зөвшөөрлийн төлбөр-0,2 сая.төг
- Тоног төхөөрөмжийн сэлбэгийн зардал-26,2 сая төг

Эдгээр зардлууд нь үйлдвэрлэл явуулахад зайлшгүй гарч байна . Нийт 218,0 сая.төг зардал гарсан байна. Үйлдвэрлэлийн зардал өндөр гарч байгаа нөгөө талаар худалдан авалт муу байгаа учир сүүлийн жилүүдэд хүчин чадлын хэмжээнд хүрч ажиллах боломжгүй байгаа юм.

# Анхаарал тавьсанд баярлалаа